


ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Даатгалын тухай хууль нь анх 1997 онд батлагдсан бөгөөд 2004 онд шинэчлэн найруулж баталснаас хойш одоог хүртэл 12 удаагийн нэмэлт, өөрчлөлт оруулсан боловч даатгалын амьдралын даатгалын хөгжил сул, технологийн шийдлийг ашиглах боломж хомс, хамтын даатгалын зохицуулалтгүй, даатгагчийн засаглал, давхар даатгалын зохицуулалтыг боловсронгуй болгох, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог сайжруулах, заавал даатгалын дэд бүтцийг боловсронгуй болгох, хуулиудын хэрэгжилтийг хангах зэрэг хэрэгцээ, шаардлагуудыг үүднээс даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулав.

Олон улсад даатгалыг амьдралын болон амьдралын бус гэж ангилж үздэг бөгөөд Монгол Улсад мөрдөгдөж буй зохицуулалтаар даатгалыг ердийн болон урт хугацааны гэж ангилж байна. Гэвч тэдгээрийн хоорондын зааг ялгааг нарийвчлан зохицуулаагүйгээс даатгуулагч нар даатгалын гэрээг буруу ойлгох, ердийн даатгалын компаниуд урт хугацааны даатгалын шинж чанарыг агуулсан бүтээгдэхүүнийг борлуулах зэрэг тохиолдлууд гарсаар байна. Иймд даатгалын ангиллын зааг ялгааг тодорхой болгох, ангиллын нэршлийг хэрэглэгчдэд илүү ойлгомжтойгоор томъёолох хэрэгцээ бий болоод байна. Олон улсад оновчтой даатгалын тогтолцоо нь нийгэм, эдийн засагт томоохон дэмжлэг үзүүлж, эдийн засаг хөгжин, тэлэх тусам эргээд даатгалын хэрэгцээ шаардлага улам нэмэгдэж байдаг харилцан хамааралтай байдаг тул манай улсын хувьд даатгалын салбарын ач холбогдлыг нэмэгдүүлэх, даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, нийгэм, эдийн засагт дэмжлэг үзүүлэх салбар болгох нь чухал байна. Даатгалын зах зээл өндөр хөгжсөн орнуудын хувьд даатгалын зах зээлийн бүтэц буюу амьдралын /урт хугацааны/ болон амьдралын бус даатгал /ердийн даатгал/-ын харьцаа 55/45 байдаг бол манай улсын хувьд уг харьцаа нь 1/99 байна.

Даатгалын салбарын хураамжийн орлогын бүтэц:



Иймд даатгалын ангиллыг олон улсын жишигт нийцүүлэн өөрчилж, амьдралын даатгалын тодорхойлолтыг илүү нарийвчилж, тогтолцоог нь боловсронгуй болгох, урт хугацааны хөрөнгө оруулалт хийх боломжийг бүрдүүлэх зэргээр амьдралын даатгал, тэтгэвэр, хуримтлалыг хөгжүүлэх, түүнийг бодлогоор дэмжих суурь зохицуулалтыг бий болгов. Дээрх өөрчлөлтүүдийг тусгаснаар даатгалын үйл ажиллагааны эрх зүйн орчны тодорхойгүй байдал буурах, даатгалын зах зээлийн бүтэц тэнцвэржих зэрэг эерэг нөлөөг үзүүлнэ.

Мөн техник технологийн хөгжил, даатгалын салбарын цахимжилттай холбоотойгоор даатгалын үйл ажиллагаа, үйлчилгээг даатгуулагчдад ойртуулах, зардлыг бууруулах боломж нээгдээд байгаа боловч өнөөгийн хууль эрх зүйн хүрээнд даатгалын гэрээ байгуулах, даатгалын нөхөн төлбөр нэхэмжлэх үйл явцад баримт бичгийг заавал бичгээр үйлдэх, баталгаажуулах шаардлагууд хэвээр үйлчилсээр байна. Иймд даатгалын салбарын оролцогчдод цахим дэвшилтэт техник технологид суурилсан даатгалын үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлж, хөгжүүлэх эрх зүйн орчныг бий болгон холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлтүүдийг тусгав.

Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь 20 бүлэг, 96 зүйлтэй. Хуулийн төслийг бүлэг тус бүрээр багцлан доор танилцуулъя.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Хуулийн төслийн нийтлэг үндэслэлд тус хуулийн зорилт, хэрэглэх хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, хуульд хэрэглэсэн нэр томъёоны тайлбаруудыг тусгалаа. Энэхүү хуулийн үйлчлэх хүрээ нь даатгалын үйл ажиллагаатай холбогдсон ерөнхий харилцааг зохицуулах, тусгайлан зохицуулсан хуультай тохиолдолд нарийвчилсан харилцааг тухайн хуулиар зохицуулахаар өөрчлөн найрууллаа. Мөн хуулийн нэр томъёо хэсэгт шинээр амьдралын даатгал, ердийн даатгал, заавал даатгал, даатгалын мэргэжлийн оролцогч, даатгалын хохирол үнэлэгч, хамтын даатгал, толгой даатгагч зэргийг тодорхойлон тусгав. Эдгээр нэр томъёог тодорхойлсноор даатгалын ангилал, хэлбэр, төрлийг нарийвчлан зохицуулах, салбарын оролцогчдын зөвшөөрлийн болон хяналт, шалгалтын үйл ажиллагаа, хамтын даатгалын зохицуулалт зэргийг хийх боломж бүрдэх юм.

Хуулийн төсөлд дурдагдсан зарим нэр томъёоны тайлбарыг доорх хүснэгтэд харуулав.

Нэр томъёо	Нэр томъёоны үүсэл	Гол утга
Актуарч /Actuary/	16-р зууны дунд үеэс үүсэлтэй Латин хэлний “тооцоо бодогч” гэсэн утгатай үг.	Эрсдэлийг үнэлж хураамжийн хэмжээг тооцоолдог, мөн нөөц сангийн хөрөнгийг тооцдог.
Андеррайтер /Underwriter/	17-р зуунд үүссэн, далайн даатгалын гэрээнд эрсдэлийг хүлээн авахад бэлэн буйгаа илэрхийлж эрсдэлийн мэдээллийн доор өөрийн нэрийг бичдэг байсан.	Даатгуулагчийн эрсдэлийг үнэлж судлаад тухайн эрсдэлийг даатгах эсэх талаар, даатгавал ямар нөхцөлөөр даатгах талаар шийдвэр гаргадаг ажилтан

Бенефициер /Beneficiary/	17-р зууны эхээр үүссэн Латин хэлний "" гэсэн утгатай үг.	Даатгалын гэрээнд нэр нь заагдсан нөхөн төлбөр авах эрх бүхий этгээд
-----------------------------	---	--

Мөн уг бүлэгт төрөөс хэрэгжүүлж буй нийгмийн болон эрүүл мэндийн албан журмын даатгалын харилцааг уг хуулиар бус холбогдох хуулиар нь зохицуулах бөгөөд харин арилжааны даатгалын компаниудаар хийгдэх заавал даатгалын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын хуулиудад заавал даатгуулахаар тусгагдсан даатгалын үйл ажиллагааг заавал даатгал гэж тодорхойлон зохицуулахаар тусгалаа.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ДААТГАЛЫН АНГИЛАЛ, ХЭЛБЭР, ТӨРӨЛ

Уг бүлэгт даатгалын ангилал, төрөл, хэлбэрийг олон улсын жишгийн дагуу шинэчлэн тодорхойлж, заавал даатгалын үйл ажиллагааг тусгайлсан хуулиар нарийвчлан зохицуулаагүй бол заавал даатгалын эрсдэл, нөхцөл, үнэлгээ, хураамжийн хэмжээг тогтоох, заавал даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавихтай холбогдон үүсэх харилцааг Хороо, холбогдох Засгийн газрын гишүүнтэй хамтран баталсан журмаар нарийвчлан зохицуулахаар тусгасан бөгөөд уг заалттай холбогдуулан даган гарах 7 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгалаа.

Мөн даатгалын үйл ажиллагаанд цахим болон дэвшилтэт техник технологийг ашиглах боломжийг бүрдүүлж, хөгжүүлэх, эрх зүйн орчныг бий болголоо. Тухайлбал, даатгалын гэрээ байгуулах, даатгалын нөхөн төлбөрийн хүсэлт гаргах, нөхөн төлбөр олгох, даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүсэх өргөдөл гаргах, даатгагчийн санхүүгийн болон бусад мэдээллийг олон нийтэд мэдээлэх болон хяналт, шалгалт хийхэд шаардлагатай мэдээ, мэдээлэл, тайлбарыг ирүүлэх зэрэг аливаа үйл ажиллагаанд даатгалын салбарын мэргэжлийн оролцогчид цахим хэлбэрийг ашиглах боломжийг бүрдүүлсэн зохицуулалтыг бий болгосноор даатгалын харилцаанд оролцогч талуудын цаг хугацаа, зардлыг хэмнэх ач холбогдолтой. Даатгалын нөхөн төлбөр олгох үйл ажиллагааг цахимжуулсантай холбогдуулан даатгагч нь даатгуулагчаас даатгалын баталгааг эх хувиар шаардах, даатгагчийн хохирол үнэлэгчийн шинэ зохицуулалттай холбоотойгоор хохирол үнэлэгчийн дүгнэлт, акт материалыг шаардах зэрэг заалтыг хасаж, зөвхөн даатгалын гэрээнд заасан тохиолдолд холбогдох мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, тодорхойлолт шаардаж болохыг тусгаснаар даатгуулагчид учирдаг хүндрэл багасаж, гомдол маргааны тоо буурах ач холбогдолтой юм.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ДААТГАГЧ, ДААТГУУЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

Даатгагч, даатгуулагчийн эрх, үүргүүдийг өмнөх бүлгээс тусдаа нэг бүлэг болгон тодорхойлсноос гадна даатгагчийн эрх, үүргүүдийг нэмэгдүүлсэн. Даатгагчийн эрх хэсэгт урьд нь даатгалын гэрээгээр зохицуулагддаг байсан даатгуулагчид олгосон

нөхөн төлбөр болон түүнтэй холбогдон гарсан зардлыг буруутай этгээдээс нэхэмжлэх эрхийг шилжүүлэн авахыг, мөн даатгалын тохиолдлыг шалган баталгаажуулах зорилгоор эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас шаардлагатай мэдээ, мэдээлэл, баримтыг гаргуулан авах эрхийг нэмэгдүүлснээр даатгалын үйл ажиллагаанд баримталдаг үндсэн зарчмуудыг хангаж, даатгуулагчид үндэслэл бүхий нөхөн төлбөрийг олгодог байх ач холбогдолтой.

Мөн даатгагч нь даатгуулагчид даатгалын гэрээ байгуулагдах үед гэрээний нөхцөлийн талаар танилцуулах, үнэн зөв, бодит мэдээлэл өгөх, даатгалын гэрээ байгуулах болон даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлэхтэй холбогдсон өөрийн томилсон даатгалын төлөөлөгчийн буруутай үйл ажиллагаанаас үүссэн хохирлыг хариуцах талаар үүрэгжүүлж өгснөөр даатгалын нөхөн төлбөр олгоход учирдаг хүндрэлийг багасгах, даатгагчийг хариуцлагажуулах зэрэг ач холбогдолтой юм. Даатгагчаа чөлөөтэй сонгох эрхийг хуульчилж өгснөөр ялангуяа даатгалын зуучлагч нар нь даатгуулагчид даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний сонголттой байх боломжийг бүрдүүлж, нөгөө талаас даатгуулагч нь даатгалын гэрээ байгуулах болон даатгалын нөхөн төлбөртэй холбогдсон баримт материал, мэдээллийг даатгагчид үнэн зөв гаргах өгөх үүрэгтэйг хуульчлав.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТӨРӨӨС ЗОХИЦУУЛАХ

Даатгалын зохицуулах байгууллага буюу Санхүүгийн зохицуулах хороо нь даатгалын салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах үндсэн үүрэгтэйгээс гадна мөн даатгалын салбарын хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотойгоор аливаа этгээдийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх боломжтой байхаар тусгасан нь хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах, үндэслэл тооцоо, судалгаа бүхий саналыг боловсруулахад ач холбогдолтой билээ. Хуулийн төсөлд заавал даатгалын хууль, тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах хүрээнд байгуулагдах Заавал даатгалын холбоог байгуулахаар заасантай холбогдуулан Даатгагчдын нэгдсэн холбоо буюу Албан журмын даатгагчдын холбоотой холбогдох зүйл, заалтуудыг хассан болно. Хороо нь даатгалын салбарын үйл ажиллагааг хянах, зохицуулах хүрээнд хуулийн шинэчлэлтэй холбогдуулан даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, даатгалын салбар дахь залилангаас урьдчилан сэргийлэх, заавал даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих зэрэг шинэ журмууд батлан гаргаж болохыг тусгав. Олон улсад даатгалын салбарын үйл ажиллагаанд оролцогч этгээдүүдийн зах зээлийн зохистой үйл ажиллагааг хуульчлан тусгадаг нийтлэг шаардлагын дагуу уг бүлгээс даатгагчийн бизнесийн үйл ажиллагаа явуулах журмыг хасаж, хуулийн төслийн 13-р бүлэгт шинээр бүлэг болгон тусгалаа.

ТАВДУГААР БҮЛЭГ

ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ

Даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн өргөдлийг бичгээр эсхүл цахим хэлбэрээр гаргаж болохоор зохицуулснаас гадна Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэн Хорооны холбогдох журамд заасан бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг уг бүлэгт тусгаж оруулав. Мөн дотоодын даатгагчдаар дамжилгүй гадаадын даатгагчдад эрсдэлээ шилжүүлэн валютын урсгал гадагшилдаг байсан байдлыг зохицуулах зорилгоор даатгагчийн даатгах зүйл хэсэгт Монгол Улсын нутаг дэвсгэрт даатгуулах үүрэг бүхий этгээдийн хүрээг “аливаа этгээд” хэмээн өөрчилсөн төдийгүй даатгуулах зүйлийн хүрээг хөрөнгөөс гадна аливаа этгээдийн амь нас, эрүүл мэнд, хариуцлага, ашиг сонирхлыг зэрэг бүх ашиг сонирхлыг гагцхүү уг хуулийн дагуу зөвшөөрөл авсан даатгагчид даатгуулахаар тусгав.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

ХӨРӨНГӨ, САНХҮҮГИЙН ЭХ ҮҮСВЭР, ТӨЛБӨРИЙН ЧАДВАР

Уг бүлэгт даатгагчийн хувьцааны шилжилтэд тавих хяналтыг өргөтгөн даатгагчийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж буй этгээд нь өөрийн өмчлөл, эзэмшилд буй хувьцааг Хорооны зөвшөөрөлгүйгээр бусдад худалдах, шилжүүлэх, барьцаалах зэргээр захиран зарцуулах, эсхүл захиран зарцуулахыг бусдад зөвшөөрөхийг хориглов. Мөн Даатгалын тухай хуульд 2022 оны 12 дугаар сард орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу даатгагч нь холбогдох этгээдээс бусад этгээдэд даатгагчийн баталгаа, батлан даалт гаргаж болох зохицуулалттай болсонтой холбогдуулан урьдчилгаа болон зээлтэй холбоотой хязгаарлалт хэсэгт холбогдох этгээдийн бусдаас зээл болон бусад үүргийн гүйцэтгэлд баталгаа, батлан даалт гаргахыг хориглох заалтыг тусгав.

ДОЛООДУГААР БҮЛЭГ

САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, АУДИТ

Хуулийн төсөлд шинээр тусаж зохицуулагдаж байгаа хөндлөнгийн даатгалын хохирол үнэлэгч, Заавал даатгалын холбоо нь даатгагчаас гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон даатгалын журамд заасны дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах үүрэгтэй байхаар зохицуулав. Дээрх этгээдүүд нь жилийн эцсийн санхүүгийн тайлангаа даатгалын журамд заасан бусад бичиг баримтын хамт дараа оны эхний сард багтаан, улирал тутмын санхүүгийн тайлангаа дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, мөн даатгагч, Заавал даатгалын холбоо нь аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлангаа дараа оны нэгдүгээр улиралд багтаан Хороонд хүргүүлэхээр тус тус Хороонд хүргүүлэхээр тусгав. Даатгалын байгууллагад аудит хийх аудитийн байгууллага нь Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлсний үндсэн дээр үйл ажиллагаагаа эрхлэхээр тусгав.

НАЙМДУГААР БҮЛЭГ

АКТУАРЧ, АКТУАРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ТАЙЛАН

2016 оны байдлаар манай улсад нийт 15 иргэн актуарчийн эрхийг аваад байсан бол 2023 оны эцсийн байдлаар 40 иргэн актуарчийн үйл ажиллагаа явуулах эрхийг Хорооноос авч байгаа буюу жилд дунджаар 4 иргэн актуарчийн эрхийг нэмж авч байна. Даатгуулагчийн эрсдэлийн үнэлгээг хийсний үндсэн дээр даатгалын хураамжийн хэмжээ, даатгалын нөөц сангийн тооцоолол зэргийг хийж гүйцэтгэдэг уг чухал ажил мэргэжлийн боловсон хүчин, тэднийг тогтвортой ажиллуулах нь даатгагчдад тулгардаг томоохон асуудлуудын нэг болоод удаж байна. Иймд даатгалын компанид ажиллах актуарч нарын шаардлагыг бууруулж заавал актуарчийн эрх авахыг шаардахыг болиулж Хороонд бүртгүүлсний үндсэн дээр актуарчийн үйл ажиллагаа эрхлэх боломжтой болгон зохицууллаа.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

ДАВХАР ДААТГАЛ БОЛОН ДААТГАЛЫН ЭРСДЭЛ ШИЛЖҮҮЛЭХ БУСАД АРГА ХЭРЭГСЭЛ

Даатгалын компаниуд 2019-2023 оны хооронд хураамжийн нийт орлогын 34.0 хувийг буюу нийт 449.9 тэрбум төгрөгийг олон улсын давхар даатгалын хураамжид зориулан гадагш шилжүүлсэн бол эргүүлэн нөхөн төлбөрт 47.6 тэрбум төгрөгийг буцаан шилжүүлэн авсан байна. Энэ нь дотоодын даатгагч нарын хүчин чадал хангалттай хэмжээнд хүрээгүй байгаатай холбоотой бөгөөд цаашид гадагш гарч буй валютын урсгалыг бууруулах, дотоодын даатгагч нарыг чадавхжуулах, тэдгээрийн үйл ажиллагааг бодлогын түвшинд дэмжих шаардлагын хүрээнд хуулийн төсөлд даатгагч нь даатгалын гэрээний дагуу хүлээсэн үүргээ давхар даатгалд даатгуулах тохиолдолд шилжүүлэх үнэлгээний тодорхой хувиас доошгүй хувийг дотоодын даатгагчид даатгуулах үүрэгтэй байхаар, ингэхдээ давхар даатгалд даатгуулах нөхцөл, шаардлагаас хамааран уг хувийг даатгал төрөл тус бүрд Хорооноос ялгаатай тогтоож болохоор зохицуулав. Мөн даатгалын эрсдэл шилжүүлэх бусад арга хэрэгсэл буюу даатгагч нар зөвхөн давхар даатгалаар бус хамтын даатгал эсхүл даатгалын эрсдэл шилжүүлэх уламжлалт бус санхүүгийн хэрэгсэл ашиглан даатгалын эрсдэл шилжүүлэх нөхцөл боломж бүрдсэнээр дотоодын даатгагч нарын эрсдэл даах чадавх нэмэгдэх ач холбогдолтой гэж үзэж байна.

АРАВДУГААР БҮЛЭГ

ДААТГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТҮҮНД ТАВИГДАХ ХЯЗГААРЛАЛТ

Олон улсын туршлагаас авч үзэхэд даатгагчид даатгалын үндсэн үйл ажиллагаа буюу эрсдэлийг үнэлэн даатгах андеррайтингийн үйл ажиллагааг эрхлэхээс гадна банктai адил баталгаа гаргах үйл ажиллагааг эрхэлж болдог байна. Мөн зохицуулагч байгууллагын зүгээс даатгагч нар баталгаа гаргах бол нэмэлт шаардлага тавьдаг эсхүл тусгай компани байгуулан түүгээрээ баталгаа гаргадаг зэрэг туршлагууд ч байдаг. Уг хуулийн төсөлд даатгагч нь Монгол улсад болон гадаад улсад гагцхүү даатгалын үйл

ажиллагаа болон даатгалын журмаар тодорхойлсон даатгалтай холбоотой үйл ажиллагаа эрхлэх бөгөөд даатгагч нь холбогдох этгээдээс бусад этгээдэд даатгагчийн баталгаа, батлан даалт гаргаж болохоор зохицуулалтыг тусгалаа. Мөн даатгагч, даатгалын зуучлагч болон аливаа этгээд нь Санхүүгийн зохицуулах хорооноос батлан гаргасан Сэндбоксын зохицуулалтын орчны журмын дагуу шинээр нэвтэрч буй технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загварыг тодорхой хугацаад туршсаны үндсэн дээр даатгалын зах зээлд нэвтрүүлэн эрхэлж болохоор зохицуулав.

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ ДААТГАГЧИЙН ЗАСАГЛАЛ

Компанийн засаглалын тогтолцоог үр дүнтэйгээр хэрэгжүүлэх нь аливаа байгууллагын урт хугацааны тогтвортой өсөлт, хөгжлийг хангахад чухал ач холбогдолтой. Мөн компанийн засаглал сайн байх нь бизнесийн үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэхээс гадна хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн хүлээлтэд тулгуурласан зах зээлийн орчин бүрдэхэд эерэгээр нөлөөлдөг. Иймд улс орнуудын хувьд санхүүгийн бүхий л салбартаа компанийн засаглалыг хөгжүүлэхэд онцгойлон анхаарч байна.

Даатгалын салбарын хувьд даатгуулагчийн төлсөн хураамж, нөөц сангийн хөрөнгийг зөв зохистой удирдах, хууль бус үйлдлийг бууруулах зорилгоор даатгалын компаниудын засаглал, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах чиглэлээр улс орнууд анхаарал хандуулах болсон. Тухайлбал, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD) нь “Даатгагчийн засаглалын талаарх ЭЗХАХБ-ын удирдамж”¹, Олон улсын даатгалын зохицуулагч байгууллагуудын холбоо (IAIS) нь даатгалын компанийн засаглал², корпорацийн (даатгалын компани) засаглалын хандлагууд³ гэх зэрэг баримт бичгүүдийг гарган гишүүн орнууд, байгууллагууддаа санал болгож, мөрдүүлэн ажиллаж байна.

Түүнчлэн, Олон улсын даатгалын зохицуулагч байгууллагуудын холбоо (IAIS)-нь даатгалын салбарт мөрдөгдөх даатгалын үндсэн зарчим, стандартуудыг багтаасан “Даатгалын тулгуур зарчим (ICP)”-г баталсан бөгөөд тус зарчмуудыг гишүүн орнуудын даатгалын зохицуулагч байгууллагууд зохицуулалтын журамдаа тусгаж, мөрдөж ажилладаг. Дээрх зарчмуудаас, 7 дугаар зарчим буюу ICP7 “Компанийн засаглал” зарчимд даатгагчийн компанийн засаглалтай холбоотой шаардлагыг тусгасан байдаг. Үүнд зохицуулагч байгууллага нь даатгагчийг даатгалын үйл ажиллагааг найдвартай бөгөөд оновчтой явуулах, хянах боломжийг бүрдүүлж чадахуйц, мөн даатгуулагчдын эрх ашгийг тодорхой хэмжээнд тусгаж хамгаалсан компанийн засаглалын зохистой

¹ OECD Guidelines on Insurer Governance, OECD, Edition 2017, <https://www.oecd.org/daf/fin/insurance/48071279.pdf> холбоосоор харна уу.

² Corporate Governance in Insurance Companies, Vladimir Njegomir, Fakultet Za Pravne I Poslovne Studije Dr Lazar Vrkatic, 2014, https://www.researchgate.net/publication/312214674_Corporate_Governance_in_Insurance_Companies/link/5876e6c108ae329d62260fdd/download холбоосоор харна уу.

³ Approaches to Group Corporate Governance; Impact Control Functions, 2014, <https://www.iaisweb.org/file/34545/issues-paper-on-approaches-to-group-corporate-governance> холбоосоор харна уу. IAIS – International Association of Insurance Supervisors (Санхүүгийн зохицуулах хороо нь энэхүү ОУ-ын байгууллагын гишүүн болно.)

бүтэцтэй байж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэхийг холбогдох хууль тогтоомжоор шаарддаг байх, мөн даатгагчийн Төлөөлөн удирдах зөвлөл, гишүүдэд тавигдах шаардлагыг зохицуулалтын хууль тогтоомждоо тодорхой тусгасан байхыг шаарддаг.

Бусад улс орнуудын сайн туршлагыг авч үзэхэд, даатгалын зохицуулалтын байгууллагууд нь дээрх стандарт зарчмыг хууль, тогтоомждоо тусгаж, даатгалын компаниудын засаглал, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах чиглэлээр тухай бүр хяналт тавин ажиллаж байна. Тухайлбал, Австрали улсын хувьд зохицуулах байгууллага нь даатгагчийн хөрөнгийн доод хэмжээ, давхар даатгалын удирдлага, эрсдэлийн удирдлага, аутсорсинг болон компанийн засаглал зэрэг стандартуудыг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг байна.

Монгол улсын хувьд анх 2007 онд “Монгол компанийн засаглалын кодекс” батлагдаж байсан бол 2022 онд Санхүүгийн зохицуулах хорооны 145 дугаар тогтоолоор “Компанийн засаглалын кодекс”-ийг шинэчлэн баталсан бөгөөд уг кодексийг нээлттэй хувьцаат компаниас гадна даатгагч, итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч банк бус санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулалтын менежментийн компаниуд дагаж мөрдөх үүргийг хүлээсэн.

Санхүүгийн зохицуулах хорооноос 2022 онд зохицуулалттай салбарын компаниудын засаглалын кодексийн хэрэгжилтэд үнэлгээ хийж тайланг⁴ боловсруулсан. Тус тайланд дурдсанаар 2022 оны байдлаар нийт 18 даатгагчийн кодексийн хэрэгжилт 71.0 хувийн гүйцэтгэлтэй байсан бөгөөд компанийн засаглалын дараах үзүүлэлтүүд хамгийн сул хэрэгжилттэй байсан байна. Үүнд:



⁴ “Компанийн засаглалын кодексийн үнэлгээний тайлан 2022 он”, www.frc.mn

Дээрх зураглалаас харахад, даатгалын компаниудын хувьд ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын ажлын үнэлгээ болон тэдэнд зориулсан чиглүүлэх болох чадваржуулах сургалтыг зохион байгуулах, мэдээллийн ил тод байдлын тайлагналын журмын хэрэгжилт зэрэг үзүүлэлтүүд хангалтгүй байгаа бөгөөд одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Даатгалын тухай хуульд даатгагчийн засаглалтай холбоотой зохицуулалт байхгүй байгаа юм.

Иймд цаашид даатгагчдын эрсдэлийн удирдлага, компанийн засаглалд тавих шаардлагуудыг олон улсын туршлагад нийцүүлэн хуульд тусгах хэрэгцээ шаардлага зайлшгүй үүсээд байгаа тул Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд даатгагч нь Хорооноос баталсан Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагыг тусгасан. Мөн даатгагчийн ТУЗ нь эрсдэлийн удирдлага, дотоод хяналт, дотоод аудит, комплайнсын хяналт, андеррайтинг, нөхөн төлбөр, харилцагчийн гомдол шийдвэрлэх, хөрөнгө оруулалтын болон шаардлагатай гэж үзсэн бусад бодлогын баримт бичиг, журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах зохицуулалтыг тусгалаа.

Түүнчлэн, даатгагч нь бүтэц, зохион байгуулалтын хувьд дотоод хяналт, комплайнсын хяналт, эрсдэлийн удирдлагын нэгжийг заавал ажиллуулах бол компанийн ТУЗ-ийн дэргэд Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлд зааснаас гадна ёс зүйн хороо, хөрөнгө оруулалтын хороо, хөрөнгө, эх үүсвэрийн удирдлагын хороо, засаглалын хороо, стратегийн хороо, ил тод байдлын хороо, хүний нөөцийн хороотой байж болохоор зохицууллаа.

Даатгагчийн мэдээллийн ил тод байдлыг сайжруулах чиглэлээр өөрийн цахим хуудсанд ил тод байршуулж, олон нийтэд мэдээлэх мэдээллийг тодорхой тусгалаа. Тухайлбал, даатгагч нь санхүүгийн тайлангаа улирал бүр өөрийн цахим хуудсаар нийтэд мэдээлэх бөгөөд даатгагчийн жилийн үйл ажиллагааны тайлан, компанийн засаглалын тайлан, хуулийн этгээдийн хэлбэр, өмчлөл, зохион байгуулалтын бүтэц бүрэлдэхүүн, төлбөрийн чадварын үзүүлэлт болон нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтны дэлгэрэнгүй мэдээлэл зэргийг өөрийн цахим хуудаст тогтмол байршуулах шаардлагыг тусгалаа.

Дээрх зохицуулалтыг тусгаснаар, даатгалын компаниудын хувьд компанийн засаглалтай холбоотойгоор зарим нэг бүтцийн өөрчлөлт хийх, даатгуулагч бүрд мэдээллийг ил тод байлгах чиглэлээр тодорхой зардлууд гарч болзошгүй хэдий ч нөгөө талаас системийн түвшинд засаглал, мэдээллийн ил тод байдал, эрсдэлийн удирдлагын тогтолцоо сайжрах, даатгуулагчдын даатгалын талаарх мэдлэг, даатгалд итгэх итгэл болон даатгуулах сонирхол нэмэгдэх, даатгуулагчдаас ирүүлэх өргөдөл, гомдлын тоо буурах, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах зохицуулалт сайжирах зэрэг эерэг нөлөөг авчирна.

АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Өнөөдрийн байдлаар даатгалын зах зээл дээр даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий 24 компани үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2023 оны эцсийн байдлаар нийт 83.4 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий

44,452 даатгалын хохирлыг үнэлж, 4.2 тэрбум төгрөгийн даатгалын хохирол үнэлгээний орлоготой ажилласан байна.

Одоогоор даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулиар зохицуулж байгаа бөгөөд тус хуулийн 3.2.4-т “даатгалын хохирол үнэлэгч” гэж даатгагч болон даатгуулагчийн нэрийн өмнөөс даатгалын гэрээтэй холбоотой нэхэмжлэлийг хянан шалгах, бодит хохирлыг тогтоох, талуудын хооронд хэлэлцээ хийх чиг үүргийг бие даан хэрэгжүүлэх, ийнхүү хэрэгжүүлсний төлөө цалин хөлс болон бусад төлбөр авах эрх бүхий этгээдийг”, 12.1-д “даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг зөвхөн компанид олгоно” гэж заасан. Өөрөөр хэлбэл, даатгалын хохирол үнэлэгч нь Хорооноос даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан компани байх бөгөөд даатгалын гэрээтэй холбоотой бодит хохирлыг тогтоох чиг үүргийг бие даан хэрэгжүүлэх зохицуулалттай.

Олон улсын практикт, даатгалын хэлбэр, бүтээгдэхүүн, даатгалын зүйлээс хамааран даатгалын хохирлыг хөрөнгийн үнэлгээчин, эмч эмнэлгийн ажилтан болон гамшиг гал түймэр, нисэх онгоц, барилга зэрэг салбарын нарийн мэдлэгтэй мэргэшсэн этгээдүүд хохирлыг үнэлэх шаардлагатай байдаг боловч манай улсад ихэвчлэн хөрөнгийн үнэлгээ хийх чиглэлээр тусгай зөвшөөрөлтэй даатгалын хохирол үнэлэгчид үйл ажиллагаа эрхэлж байна.

Мөн олон улсад даатгалын хохирол үнэлэгч этгээд нь ихэвчлэн даатгалын компанийн ажилтан, хувь хүн эсхүл хөндлөнгийн даатгалын хохирол үнэлэгч мэргэшсэн этгээд байж тухайн улсынхаа Даатгалын тухай хууль тогтоомжоор зохицуулагддаг байна. Тухайлбал, БНСУ нь даатгалын хохирол үнэлэгч этгээдэд тусгай зөвшөөрөл олгодоггүй бөгөөд харин даатгалын мэргэшсэн хохирол үнэлэгчийн эрхийг олгодог. Улмаар даатгалын компани бүр мэргэшсэн хохирол үнэлэгчийг авч ажиллуулах эсвэл хохирол үнэлгээний мэргэшсэн компанитай хамтран ажиллах шаардлага тавьдаг бөгөөд холбогдох хууль тогтоомжийн дагуу тухайн хохирол үнэлэгч нь зөвхөн хохирлыг үнэлээд зогсохгүй, хохирол учирсныг баталгаажуулах, тухайн хохирол нь даатгалын тохиолдлын улмаас учирсан эсэх дүгнэлт гаргах, хохирлыг үнэлж, нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлох, даатгалын нөхөн төлбөрийн баримт бичгийг боловсруулж, даатгуулагчид өгөх зэрэг үйлчилгээ үзүүлэхийг зөвшөөрдөг байна. Харин Филиппин улсын хувьд даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэхэд тусгай зөвшөөрөл авах шаардлагатай бөгөөд хохирол үнэлэгчийг даатгагчид нөхөн төлбөрийн хэмжээг үнэлж өгөх бие даасан хохирол үнэлэгч (independent adjuster), даатгуулагчид нөхөн төлбөрийн хэмжээг үнэлж өгөх (public adjuster) гэж ангилж, зөвшөөрлийг олгодог байна.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасан холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүргийг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд Даатгалын тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 “Аливаа этгээд даатгалын үйл ажиллагаатай холбогдон гарсан маргааныг Зохицуулах хороонд тавьж шийдвэрлүүлэх” гэж заасны дагуу хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч хянаж байна. 2023 оны жилийн

эцсийн байдлаар Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлсэн нийт өргөдөл гомдлын 51.9 хувь буюу 443 өргөдөл, гомдол даатгалын үйл ажиллагаатай холбоотой бол үүний 10.7 хувь буюу 38 өргөдөл нь даатгалын хохирол үнэлгээтэй холбоотой ирүүлсэн гомдол эзэлж байна.

Цаашид, даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэн, зохицуулалтыг сайжруулах шаардлага бий болоод байгаа бөгөөд ингэснээр даатгалын хохирол үнэлэх үйл явцыг хялбарчлах, даатгуулагчийн хохирол үнэлгээний зардлын ачааллыг бууруулах, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах болон даатгалын салбарын нэр хүндийг өсгөх ач холбогдолтой юм.

Даатгалын компани, давхар даатгагч, даатгалын актуарч, даатгалын аудитор, даатгалын андеррайтер нь бүгд даатгалын мэргэжлийн оролцогчид хамаарах атал одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа зохицуулалтаар буюу Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулиар зөвхөн даатгалын зуучлагч, төлөөлөгч, хохирол үнэлэгчийг даатгалын мэргэжлийн оролцогчид хамааруулж байгаа нь даатгалын байгууллагууд, даатгуулагч, иргэд, олон нийтэд буруу ойлголтыг хүргэж байна. Иймд даатгалын гэрээ байгуулахад даатгагч, даатгуулагчийг холбох үүргийг гүйцэтгэж буй Даатгалын зуучлагч, төлөөлөгчийн үйл ажиллагааг тусгайлсан хууль буюу Даатгалын зуучлалын тухай хуулиар, даатгалын компани, давхар даатгагч, даатгалын актуарч, даатгалын аудитор, даатгалын андеррайтеруудын нэгэн адил даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа, түүнтэй холбоотой харилцааг Даатгалын тухай хуулиар зохицуулахаар төсөлд тусгалаа.

Ингэхдээ даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаатай холбоотой дараах зохицуулалтыг шинээр тусгалаа. Үүнд:

Даатгалын хохирол үнэлэгч нь даатгагчийн томилсон хохирол үнэлэгч болон хөндлөнгийн хохирол үнэлэгч гэсэн төрөлтэй байх бөгөөд даатгагчийн томилсон хохирол үнэлэгч нь даатгалын тохиолдол болсон нөхцөлд даатгагчийн нэрийн өмнөөс даатгалын хохирлын үнэлгээг гаргах бөгөөд даатгуулагч нь хөндлөнгийн хохирол үнэлэгчээр үнэлүүлэх хүсэлтийг даатгагчид гаргасан бол, даатгагчийн томилсон хохирол үнэлэгчийн үнэлгээг хүлээн зөвшөөрөхгүй бол, мөн мэргэжлийн ур чадвар шаардлагатай, нарийн төвөгтэй байдлаар хийгдэх хохирол үнэлгээний хувьд хүсэлт гаргасан тохиолдолд хөндлөнгийн хохирол үнэлэгчид хандахаар зохицуулалтыг тусгалаа.

Даатгагчийн томилох хохирол үнэлэгч нь хохирол үнэлэгчийн энгийн зөвшөөрөл авах шаардлагагүй бөгөөд даатгагч нь холбогдох шаардлагыг хангасан хохирол үнэлэгчийг томилсон болон чөлөөлсөн тухай бүрд Хороонд ажлын 5 хоногт бичгээр мэдэгдэх зохицуулалтыг тусгалаа. Харин хөндлөнгийн хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд даатгалын хохирол үнэлэгчээр ажиллахад тохирох мэргэжил, дадлага туршлага бүхий Монгол Улсын болон гадаад улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдэд хөндлөнгийн хохирол үнэлэгчийн энгийн зөвшөөрлийг олгох бөгөөд тус зөвшөөрлийг олгохыг хүссэн этгээдийн бүрдүүлэх баримт бичиг, эрх үүргийг төсөлд тодорхой тусгалаа.

Дээрх зохицуулалтыг тусгаснаар даатгуулагч, үйлчлүүлэгчдийн хувьд хохирол үнэлгээтэй холбоотой нөхөн төлбөр нэхэмжлэх хугацаа, хохирол үнэлгээний зардал буурах, нөхөн төлбөр олгох үйл явцыг хялбарчлах, даатгалын хохирол үнэлэгчийн хувьд бие даасан хэлбэрээр хөгжих, мэргэших, даатгалын салбарын нэр хүндийг өсгөх эерэг нөлөөтэй болно.

АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ

ЗАХ ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Олон улсын даатгалын зохицуулагч байгууллагуудын холбоо (IAIS)-оос - баталсан Даатгалын тулгуур 19 дугаар зарчим буюу ICP19 “Бизнесийн ёс зүй” зарчимд даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч нь даатгалын үйл ажиллагаандаа ёс зүйн зарчмыг баримталж ажилладаг байх шаардлагыг тусгасан бөгөөд тус шаардлагыг зохицуулагч байгууллагууд нь холбогдох хууль, тогтоомждоо тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавих шаардлагатай байдаг. Тус зарчимд, даатгалын үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудыг хамтран ажиллах үедээ болон гэрээ байгуулахаас өмнө болон хойно нь даатгуулагч, үйлчлүүлэгчдэд зохистой хандах, гэрээнд тусгасан үйлчилгээгээ бүрэн үзүүлдэг байх шаардлагатай гэж заасан.

Даатгалын салбар нь санхүүгийн салбар дотроо нарийн зохицуулалт шаарддаг мэргэжлийн салбар бөгөөд даатгалын компаниуд нь даатгуулагч-иргэд, аж ахуй нэгжид тохиолдож болзошгүй эрсдэлийг шилжүүлэн авч, тэдгээрийн санхүүгийн хамгаалалт болж, ирээдүйд учрах хохирлыг нөхөн төлөх үүрэг, хариуцлага хүлээж байдаг. Иймд даатгалын зах зээлийг илүү ёс зүйтэй, хариуцлагатай, хангалттай хэмжээний дата мэдээлэл, зарчимд суурилсан салбар болгох зорилгоор даатгалын зах зээлд оролцогчдын мэргэжлийн ёс зүй болон үйлчилгээний хэм хэмжээг тогтоох, засаглалын зохистой бүтцийг бий болгох асуудал зайлшгүй чухал байгаа юм.

Даатгагч нар нь даатгалын үйл ажиллагаа эрхлэхдээ даатгуулагчид мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр урамшуулал олгох, чанаргүй гэрээ байгуулах зэрэг сөрөг үзэгдлүүд бий болж байгаа нь даатгалын үйл ажиллагаанд оролцогчдын өрсөлдөөнийг хязгаарласан, даатгуулагчийн эрх ашгийг хөндсөн зэрэг нөхцөл байдлыг үүсгэж байна. Тухайлбал, заавал даатгуулахаар заасан бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлэх үүднээс жишээ болгон Үндэсний баяр наадмын тухай хууль дахь заавал даатгалын талаар даатгагчдаас авсан асуулга судалгааны тулгарч буй саад бэрхшээлүүдийн талаарх асуултанд 11 даатгалын компаниас 3 компани “... даатгалын компаниудын тэгш оролцоог хангах...” гэж тус тус хариулсан байна. Энэ нь нэг талаас даатгагчдын шударга өрсөлдөөнийг хангах, тэгш боломжийг бүрдүүлэх, ингэснээр нөгөө талаас даатгуулагчдад сонголтыг олгох буюу тэдний эрх ашгийг хамгаалах тодорхой шаардлага байгааг харуулна. Иймд даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах хүрээнд даатгагчийн үйл ажиллагаанд зарим хязгаарлалт, үүргийг нэмж тусгах шаардлагатай байна.

Дээрх хэрэгцээ шаардлагын дагуу одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Даатгалын тухай хуульд тусгасан байгаа Зах зээлийн ёс зүйтэй холбоотой зохицуулалтыг хэвээр тусгаж, зарим зохицуулалтыг сайжрууллаа. Тухайлбал, Хороо нь даатгагчийн дагаж мөрдвөл зохих зах зээлийн ёс зүйн журмыг гаргаж болохоор тусгасан байсан зохицуулалтыг Хороо даатгалын салбарын дагаж мөрдвөл зохих зах

зээлийн зохистой үйл ажиллагааны журмыг баталж, хэрэгжилтэд хяналт тавихаар тусгалаа.

Мөн даатгалын мэргэжлийн оролцогч, даатгалын зуучлагчийн төрөлд өөрчлөлт оруулж буйтай холбоотойгоор даатгагч нь даатгалын зуучлагчаас бусад этгээдэд даатгалын борлуулалтын урамшуулал, орлогын шимтгэл зэрэг аливаа хэлбэрийн шан харамж, хөлс олгохыг хориглохоор тусгалаа. Ингэснээр даатгагч нар даатгуулагч нарт аливаа шан харамж амлах замаар шударга бус өрсөлдөх, чанаргүй гэрээ байгуулах, улмаар даатгалын хураамж нь ирээдүйд гарч болзошгүй нөхөн төлбөрийн зардалд хүрэлцэхгүй болох зэрэг эрсдэлээс сэргийлнэ.

Түүнчлэн даатгагч нь төөрөгдүүлсэн, эсхүл худал мэдээлэл агуулсан зар сурталчилгаа, мэдээлэл, товхимол болон түүнтэй адилтгах бусад баримт бичиг гаргах, тараах, тараахыг зөвшөөрөхийг хориглох бөгөөд даатгагчийн болон түүний нэрийн өмнөөс гаргасан мэдээлэл, товхимол болон түүнтэй адилтгах бусад баримт бичиг нь төөрөгдүүлсэн буюу худал мэдээлэл агуулсан, эсхүл нийтийн ашиг сонирхолд харшилсан гэж үзвэл Хороо тухайн баримт бичгийг гаргахыг хориглох, эсхүл шаардлагатай гэж үзсэн өөрчлөлт, залруулга хийж гаргахыг бичгээр даалгах зохицуулалтыг тусгалаа.

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ЗААВАЛ ДААТГАЛЫН ХОЛБОО

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Даатгалын тухай хуулийн 12¹ дүгээр зүйлд заасны дагуу албан журмын даатгалын үйл ажиллагаа явуулж буй даатгагчид нь Албан журмын даатгагчдын холбоонд гишүүнчлэлтэй байхыг үүрэг болгосон байдаг бөгөөд тус холбоо нь албан журмын даатгалын үйл ажиллагаанд хяналт тавих, мэдээлэл солилцох чиг үүрэг бүхий *даатгалын мэдээллийн нэгдсэн сан*, даатгалын тохиолдлыг шуурхай, үнэн зөв тодорхойлох боломжийг даатгагч, даатгуулагч, хохирогчид бүрдүүлэх чиг үүрэг бүхий *шуурхай алба болон албан журмын даатгалын сантай байхаар заасан*. Гэвч тус холбооны статус нь төрийн эсвэл төрийн бус эсэх нь тодорхойгүй байгаа ба байгуулагдсанаас хойш зөвхөн жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын холбоо хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулахын зэрэгцээ холбоонд нэгдсэн даатгагчидтай хэрхэн хамтарч ажиллах, салбарын хөгжилд оруулах хувь нэмэр, оролцоо, үйл ажиллагааг тодорхой зааж хуульчлаагүй.

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалаас гадна манай улсын 20 орчим хууль тогтоомжид тухайн салбарын эрсдэлийг шилжүүлэхтэй холбоотой заавал даатгалын харилцааг зохицуулсан байдаг хэдий ч хэрэгжилт хангалтгүй байгаа тул заавал даатгалын нэгдсэн зохицуулалтын орчныг бүрдүүлэх чиглэлээр холбогдох зохицуулалтыг Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгаад байна.

Энэ зохицуулалтын хүрээнд заавал даатгалын үйл ажиллагааны нэгдсэн зохион байгуулалтыг хангах зорилгоор Даатгалын тухай хуулийн 12¹ дүгээр зүйлд заасан Албан журмын даатгагчдын холбооны үйл ажиллагааг төрөлжүүлж, нарийвчлан зохицуулах нь илүү зохимжтой байна.

Иймд хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд одоогийн үйл ажиллагаа явуулж буй Албан журмын даатгагчдын холбоог өргөжүүлэх чиглэлээр зохицуулалтыг

сайжрууллаа. Тухайлбал, Заавал даатгалын холбоо нь мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, заавал даатгалын сангийн үйл ажиллагааг удирдахаас гадна даатгалын зах зээлийн судалгаа, шинжилгээ хийх, тайлан гаргах, заавал даатгалын эрсдэл хураамж болон үнэлгээний доод хэмжээг тогтоох талаар судалгаа хийх, итгэлцүүр тогтоох санал хүргүүлэх, олон нийтийн даатгалын боловсролыг дээшлүүлэх, заавал даатгалд хамруулах чиглэлээр заавал даатгалын сургалт, сурталчилгаа явуулах, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах, гишүүдийнхээ эрх ашгийг хамгаалах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгалаа.

Заавал даатгалын баталгаат сан

Санхүүгийн байгууллагууд, тэр дундаа даатгалын компаниуд дампуурч, төлбөрийн чадваргүй болох тохиолдолд даатгуулагч, үйлчлүүлэгчид ихээхэн хэмжээний санхүүгийн хохирол учирч, нийгэм эдийн засгийн хүндрэлд өртдөг.

Иймд олон улсын сайн туршлагыг авч үзвэл, улс орнууд даатгалын баталгаат санг байгуулдаг бөгөөд энэ нь даатгагч дампуурах, түүний улмаас даатгуулагч хохирох эрсдэлээс хамгаалах тодорхой түвшний хамгаалалт, баталгаа болж өгдөг байна. Өөрөөр хэлбэл, даатгагч дампуурч, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд тус сангаас даатгуулагчид даатгалын гэрээний дагуу нэхэмжлэлийг бүрэн буюу хэсэгчлэн, эсвэл тодорхой хувь хэмжээ хүртэл төлөх баталгааг гаргадаг байна.

Тухайлбал, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын гишүүн нийт 38 улсын даатгалын салбарт хийсэн судалгаагаар 26 улсад баталгаат сангийн зохицуулалтыг дараах хэлбэрийн хүрээнд хэрэгжүүлдэг байна. Үүнд:

- даатгалын салбарын эрсдэлийг бүхэлд нь хамруулсан нэгдсэн тогтолцоотой - Солонгос, Испани, Их Британи;
- даатгалын хэд хэдэн хэлбэрийг хамруулсан тогтолцоотой - Канад, Франц, Япон, АНУ;
- зөвхөн ердийн буюу амьдралын бус даатгалыг хамруулсан тогтолцоотой – Австрали, Дани, Норвег;
- зөвхөн амьдралын даатгалыг хамруулсан тогтолцоотой - Австри, Герман, Грек.

Мөн, зарим улсуудад зөвхөн ердийн даатгалын тодорхой 1 хэлбэрт хамаарах баталгаат сангийн тогтолцоотой байдаг байна. Тухайлбал:

- зөвхөн жолоочийн хариуцлагын даатгал болон автотээврийн хэрэгслийн даатгалыг хамруулсан – Австри, Бельги, Чех, Герман, Дани, Эстони, Финланд, Франц, Грек, Унгар, Израйл, Итали, Польш зэрэг улсууд;
- гамшгийн эрсдэлийн даатгалыг хамруулсан - Бельги, Финланд, Португал;
- ажилчдын гэнэтийн осол, гуравдагч этгээдийн хариуцлага, хувийн эрүүл мэндийн даатгал зэрэг нэр бүхий даатгалын эрсдэлийг хамруулсан баталгаат сангийн тогтолцоо мөн байдаг байна.

Манай улсын хувьд авч үзвэл, Хорооны 2020 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 936 дугаар тогтоолоор өгсөн үүрэг даалгавар, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага хангагдаагүй буюу төлбөрийн чадваргүй болсон тул “Соёмбо даатгал” ХХК-ийн ердийн

даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон. Үүнтэй холбогдуулан зөвхөн шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолын хүрээнд авч үзэхэд иргэд, даатгуулагчид (1 байгууллага, 5 иргэн) нийт 120,760,316.00 төгрөгийн нөхөн төлбөрийг тус компаниар гаргуулж чадахгүй, хохироод байгаа юм. Харин 2019-2021 оны хооронд Хороонд “Соёмбо даатгал” ХХК-тай холбогдох 43 өргөдөл гомдол ирүүлсэн бөгөөд нийт 40 иргэн байгууллагын 297.3 сая төгрөгийн хохирлыг тус компани барагдуулаагүй байдалтай байна.

Өнөөдрийн байдлаар Жолоочийн даатгалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д Жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгох үндэслэлүүдийг зааж өгсөн бөгөөд хуульд заасны дагуу тус сангаас даатгалгүй этгээд даатгалын тохиолдол гаргасан, даатгалын гэрээний хугацаа нь дууссан этгээд даатгалын тохиолдол гаргасан, бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан этгээд тодорхой бус, **даатгагч дампуурсан** тохиолдолд тус тус нөхөн төлбөр олгох юм. Өөрөөр хэлбэл, Даатгагч дампуурсан тохиолдолд тус сангаас зөвхөн жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөрийг олгохоор байгаа юм.

Хуулийн төсөлд заавал даатгалын нэгдсэн тогтолцоог бий болгох, бусад салбарын хуулиудад заавал даатгуулахаар тусгасан боловч хэрэгжилт, хяналт хангалтгүй байгаа заавал даатгалыг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх зохицуулалтыг тусгасантай холбоотойгоор Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалаас гадна өөр хэлбэрийн заавал даатгалын бүтээгдэхүүн зах зээлд гарах боломжтой болох юм. Иймд эхний удаад заавал даатгалд хамрагдсан даатгуулагч нарын эрх ашгийг хамгаалах тогтолцоог сайжруулах хүрээнд Заавал даатгалын баталгаат санг байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгалаа.

Даатгалын баталгаат сангийн удирдлагыг ашгийн төлөө бус хуулийн этгээд (Заавал даатгалын холбоо) хэрэгжүүлэх бөгөөд баталгаат сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаарх асуудлуудыг холбогдох журмаар нарийвчлан зохицуулахаар тусгалаа. Харин сайн дурын даатгалын баталгаат санг заавал байгуулах шаардлагагүй бөгөөд даатгагч нар хамтран байгуулж болохоор хуулийн төсөлд тусгалаа. Дотоодын практик хэрэгцээ шаардлага, олон улсын сайн туршлагад үндэслэн даатгалын баталгаат сангийн талаарх зохицуулалтыг бий болгосноор даатгуулагч нарын эрх ашгийг хамгаалах, олон нийтийн даатгалд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, улмаар салбарын нэр хүнд өсөх зэрэг эерэг нөлөөллийг бий болгох юм.

Даатгалын мэдээллийн сан

Даатгал бол эрсдэлийг бууруулах, эрсдэлээс хамгаалах санхүүгийн хэрэгсэл бөгөөд учирч болзошгүй эрсдэлийг үнэлэх, тооцоолоход төрөл бүрийн тоо, мэдээллүүд ихээр шаардагддаг. Иймд Даатгалын мэдээллийн нэгдсэн сан байгуулах, сангийн мэдээллийг ашиглан салбарын чухал шаардлагатай тооцооллуудыг боловсруулж холбогдох хураамж, төлбөрийн хэмжээг бодитойгоор тогтоох, эрсдэлийг тооцон удирдах нь даатгагч, даатгуулагчийн эрх ашиг, салбарын тогтвортой өсөлтийг хангахад чухал үүрэгтэй юм.

Олон улсын хэмжээнд ч энэ чиглэлээр ихээхэн анхаарал хандуулж дотоодын болон гадаадын хэмжээнд нэгтгэгдсэн даатгалын нэгдсэн санг байгуулж, тусгайлсан институт, байгууллагуудыг зөвхөн мэдээллийн сан, мэдээллийн боловсруулалтын чиглэлээр байгуулан ажиллаж, салбарын оролцогчдыг амин чухал, найдвартай мэдээлэл, статистикаар ханган ажиллаж байна. Тухайлбал Их Британийн жолоочийн даатгалын товчоо нь 1946 онд байгуулагдсан бөгөөд 47 улсын ижил төстэй байгууллагуудтай мэдээлэл солилцож ажилладаг, хөрш зэргэлдээ улс орнуудын даатгалын компаниудыг гишүүнчлэлээр элсүүлсэн томоохон байгууллага ба голчлон тээврийн хэрэгслийн албан журмын даатгалын мэдээллийн сантай холбоотойгоор үйлчилгээ үзүүлж байна. Азийн орнуудын хувьд БНСУ-ын Даатгалын хөгжлийн институт, Япон улсын Даатгалын хураамж тогтоогч төв байгууллага зэрэг төрийн оролцоогүй, салбарын оролцогчдын нэгдсэн удирдлагатай мэдээллийн сангийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагууд үйл ажиллагаа явуулж байна. Тус байгууллагууд нь гишүүн компаниудаас ирүүлсэн мэдээллийг нэгтгэн боловсруулж салбарын хэмжээнд хэрэглэгдэх актуар тооцоолол, хураамжийн хувь хэмжээ, нөхөн төлбөрийн мэдээлэл гэх мэт чухал шаардлагатай статистик, тооцооллыг гишүүн байгууллагууд, хэрэглэгчид, төрийн зохицуулагч байгууллагуудад хүргүүлэн хамтран ажилладаг байна.

Одоогийн байдлаар, Монгол улсад даатгалын салбарыг хамарсан мэдээллийн нэгдсэн сан байгуулагдаагүй байгаа ба зөвхөн Даатгалын тухай хуулийн 12¹.3.1 болон Жолоочийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлд тус тус заасны дагуу Албан журмын даатгагчдын холбоо нь эрхлэх асуудлын хүрээнд бие даасан албан журмын даатгалын мэдээллийн сантай байхаар тусгасан байна. Тус мэдээллийн санд даатгалын гэрээ, даатгалын тохиолдол, хохирогчид олгосон нөхөн төлбөр, даатгагч, даатгуулагч, хохирогчийн болон жолоочийн даатгалтай холбоотой бусад мэдээллийг оруулахаар хуульчилсан байна.

Хуулийн төсөлд заавал даатгалын нэгдсэн тогтолцоог бий болгох зохицуулалтыг тусгасантай холбоотойгоор Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалаас гадна өөр хэлбэрийн заавал даатгалын бүтээгдэхүүн зах зээлд гарах боломжтой болох тул заавал даатгалын эрсдэл, хураамжийн хэмжээ, үнэлгээний доод хэмжээг тогтоох, зах зээлийн судалгаа шинжилгээ хийх чиглэлээр даатгалын салбарын мэдээллийн санг байгуулах зохицуулалтыг тусгалаа.

Даатгалын мэдээллийн сангийн удирдлагыг ашгийн төлөө бус хуулийн этгээд (Заавал даатгалын холбоо) хэрэгжүүлэх бөгөөд мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилгоор мэдээллийн санд мэдээлэл төвлөрүүлэх, хуваарилах, боловсруулах, удирдах, ашиглуулах болон мэдээллийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой харилцааг Хороо, Цахим хөгжил харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталсан журмаар зохицуулахаар тусгалаа.

Даатгалын салбарт мэдээллийн нэгдсэн сан бий болж, технологижсоноор эрсдэлийг илүү нарийвчлан үнэлэх, даатгалын хураамжийг илүү бодитоор тооцоолох, статистик тооцоололд үндэслэн эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах боломжийг бүрдүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээгээ хөгжүүлэх зэрэг үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой болно.

АРВАН ТАВДУГААР БҮЛЭГ

ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА

Сүүлийн жилүүдэд олон улсын хэмжээнд төрийн олон төрлийн шууд зохицуулалт нь бизнесийн салбарын өсөлтөд таагүй нөлөө үзүүлж, салбарын хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж байгаа тул төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн оролцогчдод шилжүүлэх нь үр дүнтэй гэсэн байр суурь давамгайлах хандлагатай байна. Иймд олон улсад санхүүгийн салбараас гадна олон салбарт өөрийгөө зохицуулах зохицуулалтыг бий болгосноор төрийн давхардсан хяналт шалгалт, зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг хялбаршуулж, мэргэжлийн оролцогчдод салбарын хөгжлийн бодлогоо боловсруулахад оролцох боломжийг олгож байна.

Монгол Улс даатгалын салбарын хувьд өөрийгөө зохицуулах байгууллага буюу даатгалын мэргэжлийн байгууллагын зохицуулалт одоогоор байхгүй байгаа бөгөөд банкнаас бусад санхүүгийн салбарын хувьд үнэт цаасны зах зээлд өөрийгөө зохицуулах байгууллагын зохицуулалтыг амжилттай нэвтрүүлж, үр дүнтэй хэрэгжүүлж байна. Тухайлбал, 2013 онд батлагдсан Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад “Үнэт цаасны зах зээл дэх өөрийгөө зохицуулах байгууллага” гэсэн бүлгийг нэмж хуульчилж өгсөн ба тус хуулиар өөрийгөө зохицуулах байгууллагын хэлбэр, шаардлага, удирдлага зохион байгуулалт, бүрэн эрх, байгууллагын дүрэм, журмын шаардлага болон Хороотой харилцах харилцаа, үйл ажиллагаанд нь тавигдах төрийн байгууллагын хяналт зэргийг тусгайлан тусгаж, амжилттай хэрэгжүүлж байна.

Даатгалын салбарын хэмжээнд мэргэжлийн байгууллагын зохицуулалтыг тусгах шаардлагатай эсэх тал дээр олон улсын болон дотоодын туршлагаас судалж үзэхэд салбарын мэргэжлийн холбоодыг холбогдох хууль, журамд тусгаж өгөх замаар мэргэжлийн байгууллага болгон хөгжүүлэх нь салбарын хөгжлийг дэмжих, мөн бусад зохицуулалтын үйл ажиллагааг шилжүүлэх замаар салбарын оролцогчдын эрх ашгийг хамгаалах зэрэг олон давуу талыг бий болгож байна.

Иймд хуулийн төсөлд даатгалын мэргэжлийн байгууллагын талаар шинэ зохицуулалтыг тусгалаа. Тухайлбал, даатгалын мэргэжлийн байгууллага нь даатгалын мэргэжлийн оролцогчдоос бүрдсэн гишүүнчлэлтэй, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах, мэргэжлийн үйл ажиллагаа болон ёс зүйн нийтлэг журмыг тогтоох, гишүүдийнхээ чадавхыг дээшлүүлэх, даатгалын зах зээлийг хөгжүүлэх, тогтвортой байдлыг хангах үндсэн зорилго бүхий Хороонд бүртгүүлсэн хуулийн этгээд байх бөгөөд даатгалын мэргэжлийн байгууллагад тавигдах шаардлагыг төсөлд тодорхой тусгалаа.

Төсөлд даатгалын мэргэжлийн байгууллагын хэрэгжүүлэх бүрэн эрх болон үүргийг тусгасан бөгөөд Даатгалын мэргэжлийн байгууллага нь даатгалын зах зээлийн тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр төрийн байгууллагын боловсруулсан хууль тогтоомж, дүрэм, журмын төсөлд санал өгөх, гишүүдийнхээ үйл ажиллагаанд баримтлах нийтлэг журам, мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, заавар, зөвлөмжийг баталж, хэрэгжилтийг хангуулах, мэргэжлийн сургалт явуулах, давтан сургах, өөрийн дүрэм, журмаар тогтоосон хүрээнд гишүүдийнхээ үйл ажиллагааны зөрчлийн талаар холбогдох байгууллагад мэдээлэх, гишүүдийнхээ хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах болон Хорооноос нийтийн эрх зүйн гэрээгээр шилжүүлсэн эрхийг

хэрэгжүүлэхээр тусгалаа. Хорооноос нийтийн эрх зүйн гэрээгээр шилжүүлэх эрхэд даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх энгийн зөвшөөрөл, актуарчийн үйл ажиллагааг эрхлэх бүртгэл болон бусад эрх хамаарахаар зохицууллаа.

Мэргэжлийн байгууллагын чиг үүргийг салбарын хууль тогтоомжид тусгайлан тусган, эрх үүрэг, ажиллах хүрээг тодорхойлж, даатгалын салбарын хэмжээнд хэрэгжүүлэх төрийн зарим зохицуулалтыг мэргэжлийн байгууллагад шилжүүлэх нь даатгуулагч, даатгагч, мэргэжлийн оролцогчид, төрийн зохицуулагч болон салбарт олон давуу талыг олгохоор байна. Үүнд:

- Мэргэшсэн байдал. Мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааг салбарын мэргэшсэн боловсон хүчин удирдан явуулснаар нь практикт тулгараад буй олон асуудлыг шийдвэрлэх боломжийг олгоно. Мөн салбарын үйл ажиллагааг тогтвортой чиглүүлэн ажиллах чиг үүргийг оролцогчдод шууд олгож, илүү хариуцлагатай санаачилгатай ажиллах шаардлагыг бий болгож байна.

- Ёс зүйн стандарт. Салбарын оролцогчдоос бүрдсэн нэгдсэн биеэ даасан бүтэц бий болгосноор тухайн салбарын ёс зүйн стандартыг практикт тулгуурлан шинэчлэн тогтоож, өөрийн хяналт зохицуулалтыг нэвтрүүлснээр хөрөнгө оруулагч, даатгуулагчдын салбарт итгэх итгэлийг нэмэгдүүлнэ.

- Хяналт. Мэргэжлийн байгууллага нь төрийн зохицуулалтын байгууллага шиг улсын төсвийн хараат байдалд үйл ажиллагаа явуулахгүй зөвхөн дотоодын санхүүжилтээр үйл ажиллагаа явуулах тул дотооддоо авч хэрэгжүүлэх хяналтын тогтолцоо илүү үр өгөөжтэй болж, байнгын хяналтад шилжих боломж нээгдэнэ.

- Бодлого боловсруулах. Мэргэжлийн байгууллагад хууль тогтоомжид заасан тодорхой эрх үүргийг олгосноор салбарын оролцогчид бодлого боловсруулагчдын хамтын ажиллагаа нэмэгдэж, илүү үр дүнтэй байдлаар салбарын хөгжлийн бодлогын боловсруулж, удирдан чиглүүлэх боломж нэмэгдэнэ.

- Уялдаатай үйл ажиллагаа. Төрийн зохицуулагч байгууллагын зохицуулалтын хэт төвлөрлийг сааруулж, салбарын мэргэжлийн оролцогчдод өөрсдийн хөгжлийн тодорхойлох эрх үүргийг олгох замаар хамтын ажиллагааны уялдааг дээшлүүлнэ.

АРВАН ЗУРГААДУГААР БҮЛЭГ

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ, ТАЙЛАГНАХ

2008 онд олон улсыг хамарсан санхүүгийн хямрал болсноос шалтгаалж санхүүгийн байгууллагуудын удирдлага, хяналтыг сайжруулах талаар улс орнууд анхаарч, зарим шинэлэг зохицуулалт, шинэчлэлийг санхүүгийн бүхий л салбартаа хэрэгжүүлж байна.

Даатгалын салбар нь санхүүгийн салбар дотроо нарийн зохицуулалт шаарддаг мэргэжлийн салбар бөгөөд даатгалын компаниуд нь даатгуулагч-иргэд, аж ахуйн нэгжид тохиолдож болзошгүй эрсдэлийг шилжүүлэн авч, тэдгээрийн санхүүгийн хамгаалалт болж, ирээдүйд учрах хохирлыг нөхөн төлөх үүрэг, хариуцлага хүлээж байдаг. Иймд санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, иргэд даатгуулагч нарт хохирол тохиолдоход түүнийг нөхөн төлөх хангалттай хөрөнгөтэй байх, даатгуулагч нарын эрх ашгийг хамгаалах асуудал нь даатгалын компаниудын үйл

ажиллагаа хэвийн бөгөөд төлбөрийн чадвартай байх, эрсдэлийн удирдлагын найдвартай тогтолцоотой байхаас эхэлнэ.

Иймд даатгалын үйл ажиллагааны зохицуулалтын орчин нь тогтвортой үйл ажиллагаа явуулахад дэмжлэг болж, тэдгээрийн зөрчил, дутагдалд тохирсон урьдчилан сэргийлэх, засч залруулах арга хэмжээг авч чаддаг байхыг шаарддаг тул даатгалын салбарын эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах, түүний хяналт шалгалтыг олон улсын практик туршлага, стандартад нийцүүлэн боловсронгуй болгох, сайжруулах зайлшгүй нөхцөл шаардлага байна.

Дээрх нөхцөл шаардлагын хүрээнд одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Даатгалын тухай хуульд тусгагдсан байгаа хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтыг олон улсын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн сайжруулж, эрсдэлд суурилсан хяналт шалгалт, нэгдсэн хяналт шалгалттай холбоотой зохицуулалтуудыг хуулийн төсөлд нэмж тусгалаа. Үүнд:

Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог бүрдүүлэх, боловсронгуй болгох хүрээнд даатгагчийн үйл ажиллагаанд хийх шалгалтыг 2 жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулдаг байсан зохицуулалтыг даатгагчийн эрсдэлээс шалтгаалан шаардлагатай тохиолдолд тухай бүр зохион байгуулах боломжтой байхаар зохицууллаа. Мөн хуулийн төсөлд оруулж буй нэмэлт өөрчлөлттэй холбоотойгоор эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг даатгагч, хөндлөнгийн хохирол үнэлэгч, Заавал даатгалын холбоо болон хууль тогтоомжид заасан бусад этгээдийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэхээр тусгалаа.

Түүнчлэн, хуулийн төсөлд хяналт шалгалтад хамрагдах этгээдийн шалгалтад хамрагдахтай холбоотой үүргийг тодорхой тусгасан бөгөөд Хороо хяналт шалгалтыг хэрэгжүүлэх явцад шаардлагатай мэдээлэл, тайлбарыг зөвхөн цаасаар бус мөн цахим хэлбэрээр авч болохоор зохицуулалтыг тусгалаа.

Нэгдсэн хяналт шалгалтын тогтолцоог бүрдүүлэх хүрээнд Хороо нь тусгай зөвшөөрөл эзэмшигч болон түүний холбогдох этгээдийн үйл ажиллагаанд холбогдох төрийн байгууллагатай хамтран, мөн холбогдох этгээд нь өөр улсад бүртгэгдсэн буюу байршдаг бол Хороо тухайн орны эрх бүхий байгууллагатай мэдээлэл солилцох болон бусад хэлбэрээр хамтран ажиллаж нэгдсэн хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүллээ.

Гадаадын зохицуулах байгууллага нь өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан туслалцаа үзүүлэхийг бичгээр хүссэн тохиолдолд Хороо төсөлд тусгасан шаардлагыг хангасан тохиолдолд холбогдох, мэдээлэл, баримт бичгээр хангаж болох зохицуулалтыг тусгасан бөгөөд ингэснээр гадаадын зохицуулах байгууллагатай харилцан мэдээлэл солилцох, хамтран ажиллаж нэгдсэн хяналт шалгалт хийх боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой.

АРВАН ДОЛООДУГААР БҮЛЭГ АЛБАДЛАГА

Олон улсын даатгалын зохицуулагч байгууллагуудын холбоо (IAIS)-оос баталсан Даатгалын тулгуур 10 дугаар зарчим буюу ICP10 “Урьдчилан сэргийлэх

болон засч залруулах арга хэмжээ” зарчимд “Зохицуулагч байгууллага нь даатгагч түүний үйл ажиллагаатай холбоотой зөрчлийг илрүүлсэн тохиолдолд цаг тухайд нь засч залруулах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай. Тухайлбал, Зохицуулагч байгууллага нь тодорхой арга хэмжээ авах эсвэл тодорхой үйл ажиллагааг зогсоох талаар албан ёсоор чиглэл өгөх бөгөөд уг чиглэл нь тухайн илрээд буй зөрчил дутагдлыг шийдвэрлэхүйц тохиромжтой байх ёстой” гэж заасан.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай болон Даатгалын тухай хуульд тус тус заасны дагуу Хороо нь даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих бүрэн эрхийг хэрэгжүүлдэг.

Мөн Хороо нь даатгагч дампуурах болон даатгалын үйл ажиллагаатай холбоотой хууль бус үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй хохирлоос даатгуулагч болон олон нийтийг хамгаалах зорилгоор байнгын хяналтыг хэрэгжүүлдэг.

Иймд дээрх бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг тус бүлэгт тусгалаа. Үүнд:

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Даатгалын тухай хуульд тусгасан байгаа албадлагын арга хэмжээ авах үндэслэл болон албадлагын арга хэмжээний төрлийг Зөрчлийн тухай хуультай нийцүүлэн, холбогдох өөрчлөлтийг оруулж, Хороо нь тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, даалгавар өгөх, шалгагч томилох болох даатгалын үйл ажиллагааг зохистой явуулах талаар зөвлөх үүрэг бүхий дадлага туршлагатай мэргэжилтэн томилох гэсэн албадлагын арга хэмжээг авахаар зохицуулалтыг тусгалаа.

Мөн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх болон хүчингүй болгох үндэслэлийг тодорхой тусгаж, дээрх арга хэмжээг авах тохиолдолд Захиргааны ерөнхий хуульд заасан сонсох ажиллагааг явуулах, тодорхой агуулга бүхий мэдэгдлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүргүүлэх зохицуулалтыг тусгалаа.

Харин албадлагын арга хэмжээний нэг төрөл болох даалгавар өгөх тохиолдолд даалгаврыг албан бичиг эсхүл улсын байцаагчийн албан шаардлагаар өгөх бөгөөд тус даалгаврыг ямар агуулгын хүрээнд өгөх шаардлагатайг нарийвчлан зохицууллаа.

Даатгалын тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээдийн үйл ажиллагааг хянан шалгах үүрэг бүхий мэргэжилтэн томилох тохиолдолд нэг буюу хэд хэдэн этгээдийг шалгагчаар томилж болох бөгөөд томилогдсон шалгагч нь даатгагчийн үйл ажиллагаа, түүний шинж чанар, даатгагчийн үйл ажиллагааны тодорхой асуудлууд болон даатгагчийн болон хувьцаа эзэмшигчдийн хяналтыг хэрэгжүүлэхээр зохицуулалтыг тусгалаа.

АРВАН НАЙМДУГААР БҮЛЭГ

ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ШИЛЖҮҮЛЭХ, НЭГТГЭХ

Даатгалын компани нь даатгалын үйл ажиллагаагаа хэсэгчлэн эсвэл бүхэлд нь шилжүүлэх тохиолдолд даатгуулагчийн эрх ашиг нэн тэргүүнд хөндөгддөг. Иймд олон улсад зохицуулагч байгууллагуудын зүгээс даатгалын компаниуд даатгалын үйл ажиллагааг шилжүүлэх, нэгтгэх үед даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор зохих хяналтыг хэрэгжүүлдэг бөгөөд шилжүүлэгч болон хүлээн авагчийн санхүүгийн

нөхцөл байдал болон гэрээнд шилжүүлэгч болон хүлээн авагч хоёрын эрх ашиг бүрэн хамгаалагдсан эсэхийг мөн харгалзан үздэг байна.

Иймд олон улсын сайн туршлагад нийцүүлэн, даатгагчийн үйл ажиллагааны аливаа хэсгийг бусад этгээдэд шилжүүлэх болон даатгагчийн үйл ажиллагааны аливаа хэсгийг бусад этгээдйн үйл ажиллагаатай нэгтгэх тохиолдолд зөвшөөрлийг Хорооноос авах бөгөөд шилжүүлэх болон нэгтгэх тухай өргөдөл гаргах, өргөдлийг хянан шийдвэрлэхтэй холбогдсон үйл ажиллагааг холбогдох журмаар нарийвчлан зохицуулахаар хуулийн төсөлд тусгалаа.

АРВАН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ ДААТГАГЧИЙГ ТАТАН БУУЛГАХ

Практикт даатгагч нь сайн дурын үндсэн дээр хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр эсхүл төлбөрийн чадваргүй болж, дампуурсны үндсэн дээр даатгагчийг зах зээлээс гаргаж, татан буулгах шаардлага үүсдэг. Энэ тохиолдолд улс орнууд даатгуулагч, даатгалын гэрээ эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах асуудлыг нэн тэргүүнд тавьж, тэдэнд учирах хүндрэлийг аль болох бага байлгах зорилгоор даатгагч хуулийн этгээдүүдийг татан буулгах, зах зээлээс гаргах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжоор нарийвчлан зохицуулдаг байна. Олон улсын даатгалын зохицуулагч байгууллагуудын холбоо (IAIS)-оос баталсан Даатгалын тулгуур 12 дугаар зарчим буюу ICP12 “Зах зээлээс гарах болон татан буулгах” зарчимд мөн даатгагчийг татан буулгахтай холбоотой нарийвчилсан зохицуулалттай байхыг шаарддаг.

Иймд хуулийн төслийн арван есдүгээр бүлэгт даатгагчийг татан буулгахтай холбоотой зохицуулалтыг тусгалаа.

Даатгагч төлбөрийн чадваргүй болсон, даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд даатгагчийг татан буулгах нэхэмжлэлийг Хороо шүүхэд гаргах бөгөөд даатгагчийг шүүхийн шийдвэрээр эсхүл Хорооноос бичгээр зөвшөөрсөн тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр татан буулгана. Ингэхдээ даатгагчийн хөрөнгийн нийт үнэлгээнээс түүний хүлээсэн үүргийг хасаж үлдсэн хэсэг нь төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийн доод хэмжээг хангахгүй, татан буулгах комиссын гишүүнээр томилуулахаар санал болгож буй этгээд нь ийнхүү ажиллахад шаардлагатай ур чадвар, дадлага туршлагагүй гэж үзвэл Хороо хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр даатгагчийг татан буулгах зөвшөөрлийг олгохгүй байхаар зохицууллаа.

Даатгагч дампуурсан тохиолдолд дампуурлын хэрэг үүсгэхтэй холбогдсон ерөнхий харилцааг энэ хуулиар, зохицуулаагүй бусад харилцааг Дампуурлын тухай хуулийн дагуу зохицуулна.

ХОРЬДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлсэн өргөдөл, гомдлын тоон мэдээг сүүлийн 5 (2019-2023) жилийн байдлаар авч үзвэл нийт өргөдөл, гомдлын 50 орчим хувь нь даатгалын салбарт хамааралтай байсан бол 2023 оны жилийн эцсийн байдлаар 51.7 хувийг эзэлж байна.

Иймд даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах зохицуулалтыг сайжруулах хүрээнд даатгуулагч нь даатгалын үйл ажиллагаатай холбоотой хууль болон гэрээгээр олгогдсон өөрийн эрх ашиг зөрчигдсөн гэж үзвэл даатгагчид бичгээр эсхүл цахимаар гомдол гаргах зохицуулалтыг төсөлд нэмж тусгалаа. Даатгуулагч гомдол гаргасан тохиолдолд даатгагч нь гомдлыг хүлээн авч бүртгэснээс хойш шууд шийдвэрлэх боломжтой тохиолдолд ажлын гурав хүртэл өдөр, бусад гомдлыг 30 хүртэл өдрийн дотор шийдвэрлэж, хариуг бичгээр эсхүл цахимаар даатгуулагчид мэдэгдэнэ. Харин даатгуулагч нь даатгагчийн гаргасан шийдвэрийг эс зөвшөөрсөн, эсхүл гомдлыг шийдвэрлээгүй тохиолдолд гомдол шийдвэрлэх хугацаа дууссанаас хойш таван сарын дотор Хороонд гомдол гаргаж болохоор зохицууллаа.

Харин даатгалын үйл ажиллагаатай холбогдон гарсан маргааныг аливаа этгээд Хороонд тавьж шийдвэрлүүлэх бөгөөд Хороо түүнийг урьдчилан шийдвэрлэхээр, арбитрын хэлэлцээртэй бол тухайн маргааныг арбитрын журмаар шийдвэрлэхээр тусгалаа.

Мөн тус бүлэгт Даатгалын тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг тусгасан.

--ooOoo--